

ИРГЭНШИЛ, СОЁЛ, ДАЯАРШИЛ, МОНГОЛЫН ОРЧИН ҮЕЖИЛТ

М.Ууганбаяр

Түрэгийн социологич З.Гөкальп (1876-1924) иргэншил, соёл (Medeniyet ve Hars) хоёрыг ялгахдаа иргэншил нь олон улсад, соёл нь нэг улсад хамаатай гэж үзжээ. З.Гөкальпын санааг жишээгээр тодруулбал, ардчилал өрнийн иргэншлийг, харин Макдональдс бургер талх америкийн соёлыг төлөөлнө. Бид өрнийн иргэншлийн уламжлал буюу ардчилал, америкийн соёлын заншил буюу Макдональдс бургер талхыг ялган салгаж ойлгох ёстой (Явуз, 2001:24). Даяаршлын үр дүнд XVIII зууны сүүлээс эхлэн францын хувьсгал, гэгээрлийн үеийг даган ардчилал иргэний нийгэм, хүний эрх, эрх чөлөө, секуляризм, тэрчлэн шинжлэх ухаан, технологи тэргүүтэн өрнийн иргэншлийн ойлголтууд ч түгээмэлжин тархсан билээ (Явуз, 2001:24).

Америкжилт гэдэг нь даяаршлаар дамжин америкийн соёл дэлхий дахинаа хөгжин дэлгэрэхийг заана. Энэ нь даяаршил америкжилт болж хувирч буй гэсэн үг (Явуз, 2001:24). Дээрхээс харахад ардчилал зэрэг дэлхийд түгсэн иргэншлийн уламжлал бидэнд зайлшгүй хэрэгтэй, харин Макдональдс бургер талх гэх зэрэг тухайн нэг улс орны соёлын заншил зайлшгүй хэрэгтэй бус юм.

Иргэншил соёлын харилцааны талаарх дээрх бодлыг Монголын нийгмийн орчин үежилттэй холбон үзэх боломжтой юм. Монголчууд бид үнэндээ Макдональдс бургер талх идэж, Кока-кола ундааг уухаас эхлээд зөвхөн өдөр тутмын хэрэглээний түвшинд л иргэншиж, орчин үежиж байна. Өрнийн нийгмүүдэд орчин үеийн утгаараа хэрэглээ аж үйлдвэрийн хувьсгалтай цуг эхэлсэн ба олон нийтийн үйлдвэрлэл хангалуун төрийн үйл ажиллагаа хэрэгжсэний үр дүнд нийгмийн доод давхарга тийш дэлгэрсэн ажээ. Өөрөөр хэлбэл хэрэглээний хувьсгал өрнө дахинд үйлдвэрлэлийн хувьсгалын үр дүн болж үүсжээ.

Гэтэл Монголын нийгэмд эхлээд хэрэглээ хөгжсөнөөр өрнөдөд үр дагавар болох зүйл Монголд шалтгаан болсон байна. Монгол хүн өөрөөсөө дээд “нөгөө” буюу гадаад харь соёлтой ижилсэн, даган дуурайж өөрөөсөө хүнийссэн (Юналды, 2011:30, 63) төдийгүй соёлын үнэлэмжээсээ ч хүнийссэн. (Юналды, 2011:31, 63).

Монголын өнөөгийн нийгэмд эд юмс үйлчилгээг бүтээхээс илүү бараа бүтээгдэхүүнийг зарцуулах хэрэглээний дадал нэгэнтээ үүсэн бий болсон ба (Орчан, 2004:84), монгол хүн зөвхөн хэрэглэх хүсэл, амьдралын хэв маягийг чухалчлах болсон билээ. Н.Гөле түрэгийн өрнөжилт, орчин үежилт дуурайх дагах хэлбэрээр үүсэж, шинжлэх ухаан технологиос илүүтэй амьдралын хэв маягийн дуурайлт болохдоо Бурдьегийн хабитусын түвшинд илэрч, зөвхөн таашаал, биеийн хэл, суурьших хэлбэр, идэх уух зуршил, хувцасны маяг тэргүүтнээрээ исламч осман хүнээс өрнийн түрэг хүн рүү чиглэсэн иргэншлийн өөрчлөлт хэрэгжсэн гэж үзсэн байдаг лугаа адил өнөөгийн монголчууд Бурдьегийн хабитусын хүрээнд л иргэншиж, орчин үежиж байна. (Гөле, 1998:62)

Гэтэл өдөр тутмын амьдралын өөрчлөлт, хэрэглээ, амьдралын тав тух, суудлын тэрэг, тохилог байшин, орон сууц, хүний гадна үзэгдэх төлөв, хувцас хунар, эд юмс, хувь хүн өөрийгөө харах, тодорхойлох бусад хүмүүс түүнийг хэрхэн дүгнэх арга зам гэдэг талаасаа

монгол хүний орчин үеийн амьдралын хэв маягт бүрэн автсан адилсал (identity), адилслаа эд юмсаар тодорхойлох санаархал, монгол хүний нарциссч зан төлөв, монгол хүний таашаал жаргалд автах хедонизм, монгол хүний баялаг, хүч, статусаа бусдад үзүүлэн харуулахын тулд заавал хэрэгтэй бус тансаг эд барааг зарцуулан, бардамнах хэрэглээг шүтэх (The Sociology Book 2015: 214-219) тэмүүлэл зэрэг нь дангаараа орчин үежилт болж чадахгүй. Үнэндээ бие махбод амьдралын хэв маягийн өөрчлөлт хүнээс чармайлт шаардахгүйгээрээ идэвхгүй шинжтэй билээ.

Тодруулан хэлбэл, монголын иргэншил, орчин үежилт туйлын хүслэн болгосон харь нийгмүүдийг дагаж амьдралынх нь хэв маягийг дуурайх гэсэн утгатай юм.

Хэрэглээний зуршил дадалд хүний “нөгөө” гэх мэдрэмж сэтгэхүйгээр бус бие махбодоор дамжих нь мэдээжийн хэрэг юм. Монголчууд бидний хувьд таашаалын өөрчлөлт сэтгэлгээний өөрчлөлтөөс урьтаж өрнөжих орчин үежихийг сэтгэлгээний бус бие махбодын түвшний өөрчлөлт гэж (Чакмакчи 2014:341) ойлгож байна.

Б.Малиновски, А.Р.Рэдклифф-Браун нарын үйлдэмжийн антропологийн үзлээр эртний хүмүүс аваас байгалийн хэрэгцээнээсээ үл давах бүдүүлгүүд мөн. Б.Малиновски бүдүүлгүүдийг амь зуух аргаа олох, бэлгийн дур хүслээ хангах зэрэг амьдралын анхдагч хэрэгцээгээр л хязгаарлагдах оюун сэхээлэг бус аж үйллэг хүмүүс гэв. Түүнчлэн Б.Малиновски бүдүүлэг ард түмний тотемч ургамал амьтныг сонирхох сонирхол нь тэдний ходоодных нь хоржигнооноос өөр юунаас ч шалтгаалахгүй хэмээсэн байна (Малиновски, 1954/1948:34), (Леви-Стросс, 1966:3) (Леви-Стросс, 1978:15-16). Өнөөгийн хэрэглэгч монгол хүн иргэншлийг үнэндээ идэж уух, өмсөх эдлэх тэргүүтэн амьдралын анхдагч хэрэглээ гэж ухаардагаараа Б.Малиновскийн бүдүүлэг хүнтэй ихэд төстэй байна.

Хэрэглээнд дассан хэрэглэгч монгол хүн амин хувиа хичээгч эгоист болж хувирч байна. Хувиа хичээх үзлийг европ хүний жишээгээр тодруулан харж болно. Европ хүний нөгөө нь нийт олон байх ба европ хувь хүн аминч, хувиа хичээгч хувь хүн билээ. Европ хүн бүхнийг зөвхөн өөртөө л хүсэх, эд зүйлсийг ердөө эзэмших захирах эрмэлзэлтэй хувиа бодогч мөн. Европ хүн альтруизм юм уу бусдыг бодох бодь сэтгэл гэж юу болохыг мэдэхгүй юм. Протагор “хүн бүхний хэмжүүр” гэдэг шиг европ хүн “би бүхний хэмжүүр” гэнэ (Явуз 1998: 45-46). Энэ нь аминч үзлийн хүнлэг ёс юм (Явуз, 1998: 45-46). Гэтэл уламжлалт дорнын соёл нийгмийг хувь хүнээс илүүд тооцно. Дорнын хүн гэр бүл, эх орон, тусч чанар зэрэг нийгэмч үнэт зүйлд үнэнч байдаг билээ (Явуз, 1998: 45-46).

Номзүй

- Çakmakçı S.** 2014. *Gösterişçi Tüketim Bağlamında İki Alafranga Züppe Tipi Bihruz Bey ve Felatun Bey*. Turkish Studies International Periodical For The Languages Literature and History of Turkish or Turkic Volume 9/9 Summer Ankara. Turkey.
- Göle N.** 1988. *Batı-Dışı Modernlik Üzerine Bir İlk Desen*. Doğu-Batı Dergisi. Yıl:1. Sayı:2. Şubat-Mart-Nisan.
- Levy-Strauss C.** 1966. *The Savage Mind*. translated by George Weidenfeld. Chicago:University of Chicago Press.
- Levy-Strauss C.** 1978. *Myth and Meaning*. Toronto: University of Toronto Press.
- Malinowski B.** 1954. *Magic, Science and Religion and Other Essays*. ed. Robert Redfield Garden City, NY: Doubleday Anchor Books.
- Orçan M.** 2004. *Cemaatten Cemiyete Turkiyenin Modernlesme Pratiği*. Muhafazakar Düşünce Sayı 2.
- The Sociology Book*. 2015. DK Publishing.